



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/4/СТА-ОНТС

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Буян-Ундрах

Утас:70350757

Цахим хаяг:buyanundrakhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
3. Аудитын тайлан	7
3.1. Ерөнхий зүйл	7
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	7
3.4. Материаллаг байдал	8
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	8
3.7. Шилэн дансны мэдээлэл	9
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
3.9. Аудитын илрүүлэлт	9
Залруулсан алдаа	9
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	9
Аудитын зөвлөмж	9
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	10
4. Менежментийн захидал	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	11

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 40

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЗОРИГТБАЯР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\my doc \albanbichig\ 2021-A4.doc

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	251672727.00	256712982.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	21202713.00	41570010.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	21202713.00	41570010.00
3121	Төгрөг	21202713.00	41570010.00
31211	Төрийн сангийн харилцах	21202713.00	41570010.00
33	АВЛАГА	230470014.00	215142972.00
335	Бусад авлага	230470014.00	215142972.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	230470014.00	215142972.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	251672727.00	256712982.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	231800000.00	231800000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	231800000.00	231800000.00
413	Өглөг	231800000.00	231800000.00
4136	Бусад өглөг	231800000.00	231800000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	231800000.00	231800000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19872727.00	24912982.00
51	Засгийн газрын хувь оролцоо	19872727.00	24912982.00
512	Хуримтлагдсан үр дүн	19872727.00	24912982.00
51210	Өмнөх үеийн үр дүн	15767173.00	19872727.00
51220	Тайлант үеийн үр дүн	4105554.00	5040255.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	251672727.00	256712982.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4205554.00	5040255.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	4205554.00	5040255.00

Орхон аймгийн Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

110	Орлогын албан татвар	4205554.00	5040255.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	4205554.00	5040255.00
110002	Үйл ажиллагааны орлого	4181244.00	5040255.00
110008	Шууд бус орлого	24310.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	100000.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100000.00	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	100000.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	100000.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4105554.00	5040255.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4105554.00	5040255.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	78717467.00	20367297.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	78717467.00	20367297.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	78717467.00	20367297.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	78717467.00	20367297.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	81100000.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	81100000.00	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81100000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81100000.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81100000.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-2382533.00	20367297.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-2382533.00	20367297.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23585246.00	21202713.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21202713.00	41570010.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			15,767,173.00	15,767,173.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	15,767,173.00	15,767,173.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайланг үеийн үр дүн			4,105,554.00	4,105,554.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	19,872,727.00	19,872,727.00
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	19,872,727.00	19,872,727.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	19,872,727.00	19,872,727.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайланг үеийн үр дүн			5,040,255.00	5,040,255.00
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	24,912,982.00	24,912,982.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Орхон аймгийн Жаргалант сумын Засаг дарга Б.Зоригтбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 26-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ний хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Буян-Ундрах хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн 2020 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 03/76 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймгийн Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сум орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Орхон аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 онд Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Орхон аймгийн Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн 2020 оны нийт орлого 5,040.3 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 50.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь гүйцэтгэлийн шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон хувь хэмжээг өөрчлөөгүйтэй холбоотой юм.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,040.26 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт хөрөнгийн өсөлт нь төрийн сангийн харилцах данс дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	21,202.71	41,570.01	20,367.30
Авлага	230,470.01	215,142.97	(15,327.04)
Урьдчилгаа	-	-	-
Нийт хөрөнгө	251,672.72	256,712.98	5,040.26
Өр төлбөр	231,800.00	231,800.00	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	19,872.72	24,912.98	5,040.26
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	251,672.72	256,712.98	5,040.26

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 41,570.01 мянган төгрөг болж 20,367.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлагын дансны эцсийн үлдэгдэл 215,142.9 мянган төгрөг болж буурсан нь хугацаа хэтэрсэн зээлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж, төлүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 24,912.98 мянган төгрөг болж 5,040.26 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Жаргалант сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн 2020 онд олгох зээл олголт, бусад зардлын төсвийг 188,648.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сум хөгжүүлэх сангаас 2020 онд олгох зээлийг санхүүжүүлэхээр 188,648.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 167,446.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 21,202.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс /мөнгөн хөрөнгийн үлдэгдэл/ санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн дансанд 74,867.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 54,500.0 мянган төгрөгийн зээл олгож, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 41,570.0 мянган болсон байна.

Нэмэлт санхүүжилт

Жаргалант сумын сум хөгжүүлэх санд нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, мэдээлээгүй 1 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн 20,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж 100 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	20,000.0	1	20,000.0	0	0	0
Нийт дүн	1	20,000.0	1	20,000.0	0	0	0

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 215,142.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн тайланд залруулсан алдаа байхгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил байхгүй.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 215,142.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

2020 оны 12 сарын 31-ны байдлаар 35 зээлдэгчийн 215,142.9 мянган төгрөгийн зээл Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэгдээгүй байна.

Энэ нь Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.1.4-т "сангаас олгосон зээлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн хөтөлж, холбогдох мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчих

1.3. Өгсөн зөвлөмж:

Сангаас олгосон зээлийн холбогдох мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн захирагчийн 2021.02.25-ны өдрийн 01/276 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25

Аудитын код: ОРА-2021/4/СТА-ОНТС

Аудитын нэр: Орхон аймгийн Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Шалгагдсан байгууллагын нэр: Орхон аймгийн Жаргалант сумын сум хөгжүүлэх сан.

(мянган төгрөг)

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	2020 оны 12 сарын 31-ны байдлаар 35 зээлдэгчийн 215,142.9 мянган төгрөгийн зээл Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэгдээгүй байна.	215,142.9	Зөвлөмж өгөх	Засаг дарга, нягтлан бодогч	Б.Зоригтбаяр, З.Сайнзаяа
	ДҮН	213,492.9			